



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 18

Рашаант

Үндэсний бичгийн дэд хөтөлбөр батлах
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн “ж”, Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Үндэсний бичгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Үндэсний бичгийн дэд хөтөлбөрийг сурталчилах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг жил бүр иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнахыг Засаг даргад даалгасугай.
3. Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хамтран ажиллах болон хөдөлмөрийн гэрээнд үндэсний бичиг сурах талаар тусгаж биелэлтийг дүгнэж ажиллахыг байгууллагын Дарга, Захирал, Эрхлэгч нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ЖАРГАЛСАЙХАН



4801190039



Сургууль
ашигтай
болговсн
10000

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 03 дугаар сарын 27 ны өдрийн 18 дугаар тогтоолын хавсралт

Нэг. Үндэслэл, өнөөгийн нөхцөл байдал

XIII зуунаас эхлэн монголчууд монгол бичгийг төрийн үйл хэрэгт болон шинжлэх ухааны бүтээл туурвилыг бүтээхэд хэрэглэсээр ирсэн албан ёсны сонгодог төдийгүй дэлхийн бичиг соёлын нандин өв юм. Монгол үндэстэн оршин тогтнох соёл, сэтгэлгээний баталгаа болсон монгол бичгээ сурч эзэмших, судлан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, өвлүүлэх, хөгжүүлэх нь Монгол хүн бүрийн төдийгүй дэлхийн бичиг соёлын өв сангийн өмнө монголчуудын хүлээж байгаа эрхэм үүрэг юм.

Өнөөгийн монгол бичгийн сургалт, хэрэглээний нөхцөл байдалд хийсэн шинжилгээний дүнгээр цаашид монгол бичгийн сургалтыг дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, насан туршийн боловсролын салбарт эрчимжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, стандарт дүрэм, журмыг шинэчлэн батлах, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, үүрэг оролцоог нэмэгдүүлэх, уялдуулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Мөн Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Монгол хэлний тухай хуулийн 11 дүгээр зүйлд Монгол Улсын Засгийн газрын хүлээх үүргийг тодорхойлохдоо "монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх" гэж, мөн хуулийн 7.2-т "Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна" гэж, 24.2-т "Энэ хуулийн 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө" гэж тус тус заасан үндэслэлээр "МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР III" хөтөлбөрийг боловсруулах нийгмийн хэрэгцээ, нэгэн чухал хүчин зүйл болсон байна.

Дээрх шалтгаан, үндэслэлтэй уялдуулан,

- Орон нутгийн хэмжээнд дорвитой үйл ажиллагаа зохион байгуулж, үндэсний бичиг үсгийн боловсролыг сайжруулахад онцгойлон анхаарах,
- Үндэсний бичгээр бичигдсэн ховор ном зохиол, судар бичгийн судалгаа гаргаж, өвлөн уламжлуулах, устаж үгүй болохоос сэргийлэх,
- Сумын нийт төрийн албан хаагчаас үндэсний бичгийг огт мэдэхгүй- 29.4%, үндэсний бичгийн анхан шатны мэдлэгийн түвшинг тогтоох шалгалтын гүйцэтгэл 45.7 %-тай буюу хангалтгүй үнэлэгдсэн зэрэг хэрэгцээ шаардлагад үндэслэн Өлзийт сумын "ҮНДЭСНИЙ БИЧГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР"-ийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага үүссэн болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

2.1. 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжихэд монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг бүрдүүлж, сумын төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадварыг ахиулахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

2.2.1. Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх;

2.2.2. Монгол бичигт сургах ажлыг шинэ шатанд гаргаж, үр дүнд хүргэх;

2.2.3. Монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

2.3. Хөтөлбөрийг 2021-2022 онд (2 жил) хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. Монгол бичгийн байгууллагуудын цахим хуудас нээж, хэрэглээг тогтмолжуулах;

3.1.2. Цахим орчинд монгол бичгээр бичвэр боловсруулах чиглэлийн сургалтыг эрчимжүүлэх;

3.1.3. Монгол бичгээр уламжлан ирсэн түүх соёлын үнэт дурсгалуудыг хамгаалах, бүртгэн авах;

3.1.4. Монгол бичгээр дагнан гардаг сонин, сэтгүүл, тогтмол хэвлэлийн захиалгын тоог нэмэгдүүлэх

3.1.5. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, нэрийн хуудас, бүтээгдэхүүний шошго, танилцуулга, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг монгол бичгээр бичиж хэвшүүлэх;

3.1.6. Монгол бичгээр угийн бичиг хөтлөх дадлыг хэвшүүлэх

3.1.7. Монгол бичгийн бичлэгийн төрлүүдээр хөдөлмөрчид ба сурагчдын бүтээсэн бүтээлээр үзэсгэлэн зохион байгуулах

3.2. Монгол бичигт сургах ажлыг шинэ шатанд гаргаж, үр дүнд хүргэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. Сумын төрийн албан хаагчдын хүрээнд үндэсний бичгийн түвшин тогтоох ажлыг зохион байгуулах

3.2.2. Монгол бичгийн хичээлээр ард иргэдийг сургах, мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах

3.2.3. Монгол хэл, бичгийн хичээлийн мэдлэг чадвар эзэмших орчин нөхцөлийг бүрдүүлэх

3.2.4. монгол бичгийн сумын олимпиадыг жил бүр зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, 2021 оноос эхлэн хэрэгжүүлэх;

3.2.5. монгол бичгийн албан бус сургалт явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг хөхиүлэн дэмжих;

3.2.6. байгууллага, хамт олноороо монгол бичигтэн болох аян, хөдөлгөөн өрнүүлэх.

3.3. Монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. монгол бичиг сурч судлах, түгээн дэлгэрүүлэхэд иргэд, олон нийтийн идэвхийг өрнүүлэх, аяныг зохион байгуулах, оролцох;

3.3.2. насан туршийн боловсролын төвд албан бус сургалтаар иргэдэд монгол бичиг сургахыг дэмжих;

Дөрөв. Хөтөлбөрийн хүрэх үр дүн:

4.1. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшилсэн байна.

4.2. Үндэсний бичгийн хэрэглээний орчин сайжирсан байна.

4.3. Үндэсний бичгийн хичээлийг зохион байгуулах орчин, нөхцөл дээшилсэн байна.

4.4. Ард иргэдийн үндэсний бичгээ эрхэмлэн дээдлэх үзэлд эергээр нөлөөлсөн байна.

Тав. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ үнэлгээ:

2021 оны 1-12 сар:

Хөтөлбөрийг сурталчлах, гарааны үнэлгээ хийх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулж, явцын үнэлгээ хийх (уралдаан тэмцээн, аян өрнүүлэх)

2022 оны 1-12 сар:

Хөтөлбөрийн хэрэгжилтэнд дүгнэлт гарган, хөтөлбөрийг сайжруулж, эцсийн үнэлгээ хийж, үр дүнг тооцох

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ.


- орон нутгийн төсөв;
- гадаадын зээл, тусламж,
- олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив;
- хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Төрийн байгууллагууд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусгаж хэрэгжүүлэх бөгөөд түүний хэрэгжилтэд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хяналт тавина.

Сумын “Үндэсний бичгийн дэд хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчаас сумын Засаг даргатай байгуулах гэрээнд тусган ажиллана.


Хөтөлбөр боловсруулсан;

Ажлын хэсгийн ахлагч:



С.Отгонмөнх

Гишүүд:



Б.Энхжаргал



М.Нарангарав



Б.Жавзмаа




Н.Алтантуяа



Н.Алтанзул



С.Сугиржав



С.Отгонмаа



Э.Энхмаа